



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 22

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 4,599,190.24 (Дөрвөн сая таван зуун ерэн есөн мянга нэг зуун ерэн төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 3,577,148 (Гурван сая таван далан долоо нэг зуун дөчин найм) төгрөгийн үлдэх өртөгтэй 09-09 ДУА улсын дугаартай Фургон маркийн автомашиныг “Мандалын гэгээ” хот тохижуулах аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан), “Мандалын гэгээ” хот тохижуулах аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (Д.Очбадрах) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Шилжүүлэх хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.МӨНХЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
22 дугаар тогтоолын хавсралт



Орон нутгийн өмчийн газрын балансаас
балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	УАЗ ФУРГОН 2206	2018	ш	1	4,599,190.24	1,022,042.24	3,577,148	"Мандалын гэгээ" хот тохижуулах газар ААТҮГ
Нийт дүн				2	(Дөрвөн сая таван зуун ерэн есөн мянга нэг зуун ерэн төгрөг хорин дөрөв мөнгө) төгрөг	(Нэг сая хорин хоёр мянга дөчин хоёр төгрөг хорин дөрөв мөнгө)	(Гурван сая таван зуун далан долоон мянга нэг зуун дөчин найм) төгрөг	